



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 44 (181)

Монгол Улсын Хууль:

- *Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн тухай*

Монгол Улсын Их Хурлын тогтоол:

- *Төрөөс мөнгөний бодлогын талаар 2001 онд баримтлах чиглэл батлах тухай*

Монгол Улсын Засгийн газрын тогтоол:

- *Журам батлах тухай (2000-2001 оны хичээлийн жилд дотоодын их сургууль, коллежид суралцаж байгаа зарим суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх тухай)*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2000 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны арваннэгдүгээр сарын 28 №44 (181)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

478. Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн тухай
(2000-11-17-ны хууль) 777

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

479. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2001 онд баримтлах
чиглэл батлах тухай Дугаар 44 779

480. Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын
хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл буцаах тухай Дугаар 46 780

481. Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн
төсөл буцаах тухай Дугаар 47 780

482. Кассын машин ашиглах тухай хуулийн төсөл буцаах
тухай Дугаар 48 781

483. Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн тэнцлийн
талаар Дугаар 49 781

484. Галт зэвсгийн тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 50 781

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

485. Жадамбын Пүрэвт Монгол Улсын соёлын гавьяат
зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 157 781

486. "Үнэн" сонины зарим ажилтныг одон, медалиар
шагнах тухай Дугаар 158 781

487. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 159 782

488. Шүүгчийн албан тушаалд томилох тухай Дугаар 160 782

489. Тэгшбуянтын Пүрэвжавт Монгол Улсын Хүний
гавьяат эмч цол хүртээх тухай Дугаар 161 782

490. Хайдавын Төмөрбаатарт Монгол Улсын гавьяат
жүжигчин цол хүртээх тухай Дугаар 162 783

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

491. Журам батлах тухай Дугаар 158 783

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 11 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН 2001 ОНЫ ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын төвлөрсөн төсвийн 2001 оны орлогын нийт дүн, нэр төрлийн хэмжээг дор
дурдсанаар баталсугай:

1.1. ОРЛОГО-БҮГД

1.1.1 Албан татварын орлого

1.1.1.а. орлогын албан татвар

/мянган төгрөг/

314.163.364.7

239.430.899.0

36.044.727.9



1.1.1.б.өмчийн татвар	1.900.000.0
1.1.1.в.нэмэгдсэн өртгийн албан татвар	89.063.051.4
1.1.1.г.онцгой албан татвар	32.378.449.0
1.1.1.д.автобензин, дизелийн түлшний албан татвар	4.599.902.5
1.1.1.е.гаалийн албан татвар	30.101.900.0
1.1.1.ж.бусад албан татвар	2.544.495.9
1.1.1.з.нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	42.798.372.3
1.1.2.Татварын бус орлого	66.732.465.7
1.1.2.а.хувьцааны ногдол ашиг	11.899.929.7
1.1.2.б.бусад орлого	11.269.540.0
1.1.2.в.түрээсийн орлого	7.427.580.0
1.1.2.г.газрын тосны орлого	500.000.0
1.1.2.д.төсөвт байгууллагын өөрийн орлого	24.135.416.0
1.1.2.е.навигац /өнгөрөлт/-ын орлого	10.000.000.0
1.1.2.ж.Монголбанкнаас орох орлого	1.500.000.0
1.1.3.Гадаад тусламжийн орлого	8.000.000.0

2 дугаар зүйл. Улсын төвлөрсөн төсвийн 2001 оны зарлагын нийт дүн, үүний дотор цалин, хөрөнгө оруулалт, батлан хамгаалах арга хэмжээний зардал, төвлөрүүлэн захирагчийн санхүүжилт, тэтгэврийн даатгалын санд өгөх татаасын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

2.1.ЗАРЛАГА –БҮГД	404.637.450.5
2.1.1.цалингийн сан	33.269.257.4
2.1.2.хөрөнгө оруулалт	29.670.000.0
Үүнээс: -шинээр эхлэх барилга объектын нийт төсөвт өртөг	16.076.900.0
Үүний дотор: -2001 онд санхүүжүүлэх объектын төсөвт өртөг	5.600.700.0
2.1.3.батлан хамгаалах арга хэмжээний зардал	25.543.425.2
2.1.4.Улсын Их Хурлын төсөв	1.954.660.7
2.1.5.Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсөв	647.940.4
2.1.6.Монгол Улсын Ерөнхий сайдын төсөв	150.085.2
2.1.7.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн төсөв	37.576.0
2.1.8.Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөв	95.049.5
2.1.9.Улсын дээд шүүхийн төсөв	184.511.2
2.1.10.орон нутгийн шүүхийн төсөв	1.481.070.8
2.1.11.Прокурорын төсөв	1.131.876.3
2.1.12.Улсын аюулгүй байдлыг хангах газар	2.078.027.1
2.1.13.тэтгэврийн даатгалын санд өгөх татаас	20.187.553.3

3 дугаар зүйл. Улсын төвлөрсөн төсвөөс 2001 онд аймаг, нийслэлийн төсөвт өгөх татаасын хэмжээг дор дурдсанаар тогтоосугай:

	БҮГД	Үүнээс сум хөгжүүлэх сан
3.1.ТАТААСЫН ДҮН –БҮГД	56.660.775.8	530.000.0
3.1.1.Архангай	3.036.414.5	5.000.0
3.1.2.Баян-Өлгий	3.308.616.7	15.000.0
3.1.3.Баянхонгор	3.199.174.4	15.000.0
3.1.4.Булган	2.663.602.0	10.000.0
3.1.5.Говь-Алтай	3.762.095.8	20.000.0
3.1.6.Дорноговь	2.174.343.7	35.000.0
3.1.7.Дорнод	2.491.649.3	15.000.0
3.1.8.Дундговь	1.863.719.3	55.000.0
3.1.9.Завхан	3.244.764.7	25.000.0
3.1.10.Өвөрхангай	3.032.387.3	75.000.0
3.1.11.Өмнөговь	2.171.395.5	45.000.0
3.1.12.Сүхбаатар	2.877.434.8	25.000.0
3.1.13.Сэлэнгэ	2.081.059.1	0.0
3.1.14.Төв	2.739.663.5	45.000.0
3.1.15.Увс	3.549.933.6	15.000.0
3.1.16.Ховд	3.262.536.2	5.000.0
3.1.17.Хөвсгөл	3.924.000.0	100.000.0
3.1.18.Хэнтий	2.905.435.6	15.000.0
3.1.19.Дархан-Уул	867.949.3	0.0
3.1.20.Улаанбаатар	2.556.087.8	0.0
3.1.21.Орхон	316.451.6	5.000.0
3.1.22.Говь-Сүмбэр	632.061.1	5.000.0

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ



2000 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2001 онд баримтлах чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2001 онд баримтлах чиглэлийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газартай хамтран зохион байгуулж, дунг улирал тутам Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монголбанк (О.Чулуунбат)-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ

Монгол Улсын Их Хурлын 2000 оны 44 дүгээр тогтоолын хавсралт

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2001 ОНД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2001 онд баримтлах чиглэл нь төгрөгийн тогтвортой байдлыг үргэлжлүүлэн хангах, эдийн засгийн өсөлтийг дэмжих, санхүүгийн зуучлалыг, түүний эрх зүйн болон эдийн засгийн орчныг боловсронгуй болгох замаар бэхжүүлэх, банк, банк бус санхүүгийн тогтолцооны үр ашгийг нэмэгдүүлэхэд оршино. Энэ хүрээнд бодлогын чанартай дараахь арга хэмжээ авч, хэрэгжүүлнэ:

Нэг. Мөнгөний бодлогын талаар

Эдийн засаг дахь нийт мөнгөний өсөлтийг 30 хувиас хэтрүүлэхгүй бөгөөд үнийн өөрчлөлттэй уялдуулан хүүг бууруулах замаар бодит эдийн засгийн зээлжих боломжийг нэмэгдүүлэх, түүний дотор уул уурхай, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах болон экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжих, газар тариаланг сэргээхэд илүү анхаарна.

Бодит эдийн засгийн хүрээний өндөр үр ашигтай зарим төслүүдийг зээлжүүлэхэд Төв болон арилжааны банкууд хуулийн хүрээнд хамтран ажиллах, түүнд гадаад зах зээлээс хямд үнэтэй санхүүгийн эх үүсвэр ашиглах боломжийг судална.

Мөнгөний бодлогын хэрэгслийн хоорондын уялдаа холбоог нягтруулж, уян хатан хослолыг хангаж ажиллана.

Төв банкны үнэт цаасны хүүгээр дамжуулан бодит хүүг эерэг түвшинд тогтоож, арилжааны банкны зээлийн хүүг бууруулах бодлогыг үргэлжлүүлэн баримтална.

Мөнгөний зах зээлийг хөгжүүлэх, үнэт цаасны

хоёрдогч захын үйл ажиллагааг идэвхжүүлэх замаар санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

Банкны бүтцийн өөрчлөлтөд зориулж Засгийн газраас гаргасан өрийн бичиг, зээллэгээг мөнгөжүүлэх, тэдгээрийн хүү, нөхцөлийг тодорхой болгох, хөрвөх чадварыг сайжруулах замаар санхүүгийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч, Монголбанк Засгийн газрын бүх талын хамтын ажиллагааг идэвхжүүлнэ.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом өөрчлөлтийг зохицуулан удирдаж, гадаад худалдааны тэнцлийн байдалд зохицсон экспортыг урамшуулахад чиглэгдсэн ханшны уян хатан бодлогыг баримтална.

Гадаад валютын улсын цэвэр нөөцийг оны эцсийн байдлаар импортын 12 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд барина.

Хоёр. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах талаар

Банкны зээл заавал эргэн төлөгддөг байх зарчмыг бүрэн хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж байгаа хуулиудын заалтыг өөрчлөх, банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөрийн чадварын үнэлгээ болон бусад үзүүлэлтүүдийг харгалзан Монголбанкнаас авах албадлагын арга хэмжээг тодорхой болгох чиглэлээр банкны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга хэмжээ авна.

Хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хадгаламжийн даатгалын



тогтолцоог нэвтрүүлэхтэй холбогдсон арга хэмжээ авч, хэрэгжүүлж эхэлнэ.

Банк бус санхүүгийн байгууллагын эрх зүйн орчныг сайжруулж, үйл ажиллагааг нь өргөжүүлнэ.

Хувьчлах бэлтгэл нь хангагдсан төрийн болон төрийн өмчийн оролцоотой банкуудыг хувьчлах ажлыг зохион байгуулна.

Хөдөө аж ахуйн банкны бүтцийн өөрчлөлтийг олон улсын байгууллагуудтай тохиролцсоны дагуу үргэлжлүүлнэ.

Банкуудын дотоод хяналтыг боловсронгуй болгох үүднээс олон улсад хэрэглэгдэж байгаа эрсдлийн удирдлагын шинэлэг арга хэрэгслүүдийг арилжааны банкуудын үйл ажиллагаанд хэвшүүлэх ажлыг зохион байгуулна.

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан хөдөө, орон нутаг дахь банк, санхүүгийн үйлчилгээг өргөжүүлнэ.

Банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг нийтэд нээлттэй, ил тод байлгах,

мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох замаар зах зээлийн харилцаанд оролцогч талуудад зөв шийдвэр гаргах нөхцөл, боломжийг сайжруулна.

Банк, банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг боловсронгуй болгох, тэдгээрээс эрсдлээ зөв тооцох, хянах чадвараа дээшлүүлэхэд нь түлхүү анхаарна.

Банк, санхүү, даатгалын үндэсний стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулна.

Гурав. Төв банкны бие даасан байдлын талаар

Төв банкны бие даасан байдлыг бэхжүүлэх, түүнийг үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байлгах арга хэлбэрүүдийг өргөжүүлнэ.

Монголбанкны төв, орон нутгийн салбар, төлөөлөгчийн газрын бүтэц, бүсчлэлийг боловсронгуй болгох, үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын механизмыг олон улсын стандартад нийцүүлэх, төсвийн удирдлага, санхүүжилтийн шинэчлэлийг эрчимжүүлэх арга хэмжээ авна.

— МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ —

2000 оны 11 дүгээр сарын 16—ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлсэн Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг экспортод гаргаж байгаа мал аж ахуйн гаралтай түүхий эдэд шинээр татвар ногдуулах шаардлагагүй гэсэн үндэслэлээр хууль санаачлагчид буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ

— МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ —

2000 оны 11 дүгээр сарын 16—ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг мал бүхий иргэний

малаас орох орлогод ногдуулах татварыг шатлалгүйгээр тогтоох нь зүйтэй гэсэн үндэслэлээр хууль санаачлагчид буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Кассын машин ашиглах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

төслийг уул хуулийг батлан гаргах шаардлагагүй гэсэн үндэслэлээр хууль санаачлагчид буцаасугай.

Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлсэн Кассын машин ашиглах тухай хуулийн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн тэнцлийн талаар

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: Өмч хувьчлалын орлого, гадаадын санхүүгийн зээлийн хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс давж биелсэн тохиолдолд төсвийн өр барагдуулахад 12.0 тэрбум төгрөг болон төвлөрсөн

төсвөөс хийх хөрөнгө оруулалтыг 4.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн хэрэгжүүлэхээр тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Галт зэвсгийн тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 11 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар бүхэлд нь батлаагүй тул хууль санаачлагчид буцаасугай.

Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлсэн Галт зэвсгийн тухай хуулийн төслийг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

Жадамбын Пүрэвт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Хэвлэл мэдээллийн байгууллагад удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж улс орны амьдралын цаг үеийн болон хэтийн төлөвийн чухал асуудал хөндсөн олон зуун өгүүлэл, тэмдэглэл, найруулал, нийтлэл бичиж, уншигчдыг мэдээллээр хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

"Үнэн" сонины хууль, эрх зүйн албаны дарга, сэтгүүлч Жадамбын Пүрэвт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

"Үнэн" сонины зарим ажилтныг одон, медалиар шагнах тухай

"Үнэн" сонинд олон жил амжилт гарган ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон,

медалиар шагнаасугай.



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Гэндэнгийн Бямбажал

-“Үнэн” сонины хариуцлагатай нарийн бичгийн дарга

“АЛТАН ГАДАС” ОДОНГООР:

1. Дугарсүрэнгийн Батмөнх
2. Ноосонборын Бөхдамбий
3. Цэрэнсодномын Ганбат
4. Самбуугийн Товуудорж

- “Үнэн” сонины орлогч эрхлэгч
- “Үнэн” сонины гэрэл зургийн сурвалжлагч
- “Үнэн” сонины ерөнхий эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч
- “Үнэн” сонины сурвалжлагч

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Банзрагчийн Энхтуяа
2. Хишигбадрахын Эрдэнэчимэг

- “Үнэн” сонины сурвалжлагч
- “Үнэн” сонины операторч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын “Шүүхийн тухай хуул”-ийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

Өөр шатны шүүхэд шилжин ажиллах болсонтой холбогдуулан Баасангийн Лхамхүүг Увс

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 160

Улаанбаатар хот

Шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсгийг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай.

Баасангийн Лхамхүүг Увс аймаг дахь сум

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

Тэгшбуянтын Пүрэвжавт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, рентген-радиологийн албыг үүсгэн байгуулах, шинжилгээ, оношлогооны шинэ аргуудыг нэвтрүүлэх, олон мянган өвчтний оношийг тогтоох, эмчлэн эдгэрүүлэхэд болон мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

Анагаах ухааны их сургуулийн багш, Улсын клиникийн төв эмнэлгийн рентген тасгийн зөвлөх эмч Тэгшбуянтын Пүрэвжавт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

Хайдавын Төмөрбаатарт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж орчин үеийн зохиолын болон гадаад орнуудын эстрадын дуунуудыг мэргэжлийн өндөр түвшинд чадварлаг дуулж, монголын эстрадын урлагийг үүсгэн хөгжүүлэх, сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь

үнэлж Улсын филармонийн "Баян монгол" чуулгын дуучин Хайдавын Төмөрбаатарт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 10 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Их сургууль, коллежийн зарим суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталж, 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсүгэй.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт

тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ

САЙД

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ

УХААНЫ САЙД

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН

САЙД

Н.ЭНХБАЯР

А.ЦАНЖИД

Ч.УЛААН

Засгийн газрын 2000 оны 158 дугаар тогтоолын хавсралт

2000-2001 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ДОТООДЫН ИХ СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИД СУРАЛЦАЖ БАЙГАА ЗАРИМ СУРАЛЦАГЧИЙН СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙГ ТӨРӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Өмчийн бүх хэлбэрийн магадлан итгэмжлэгдсэн их сургууль, коллежид 2000-2001 оны хичээлийн жилээс эхлэн зохих журмын дагуу элссэн нэн ядуу, малчин, 3 ба түүнээс дээш хүүхэд нь дээр дурдсан сургуулийн өдрийн ангид суралцаж байгаа нэг суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2. Нэн ядуу, малчин, 3 ба түүнээс дээш хүүхэд нь их сургууль, коллежид зэрэг суралцаж байгаа тохиолдолд өрх тус бүрийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлнэ.

3. Төрийн албаны тухай хуулийн дагуу

төрийн албан хаагчийн гэр бүлээс их сургууль, коллежид суралцаж байгаа нэг суралцагчийн сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэхдээ энэхүү журмын 2 дугаар заалттай давхардуулан олгохгүй.

4. Боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургалтын төрийн сангаас суралцагчтай байгуулах сургалтын төлбөрийн гэрээний загварыг батална. Сургалтын төрийн сангаас суралцагчтай байгуулсан энэхүү гэрээг үндэслэн суралцаж байгаа сургуулиар нь дамжуулан сургалтын төлбөрийн санхүүжилтийг олгоно.

5. Сургалтын төрийн сан нь суралцагчийн сургалтын төлбөрийг жил бүрийн төсөвтөө тусган санхүүгийн асуудал



эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай эргэн тооцож байна.

6. Суралцагчийн зохих журмын дагуу чөлөөтэй байсан хугацааны сургалтын төлбөрийн санхүүжилтийг түр түдгэлзүүлнэ.

Хоёр.Сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэх нөхцөл

7. Дор дурдсан нөхцөл бүхий өрхийн зөвхөн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг төр хариуцна:

а/нийт малыг нь богд шилжүүлснээр 200 хүртэл толгой мал бүхий зөвхөн малчин;

б/Үндэсний статистикийн газраас тогтоосон бүсийн амьжиргааны түвшингийн 40 хувиас доогуур орлоготой бөгөөд тэрхүү орлогынхоо хэмжээгээр хязгаарлагдмал хэрэглээтэй нэн ядуу;

в/3 ба түүнээс дээш хүүхэд нь их сургууль, коллежид зэрэг суралцаж буй.

Гурав.Бүрдүүлэх материал

8. Суралцагч суралцаж буй сургуульдаа доорхи материалыг бүрдүүлэн өгнө:

а/суралцагчийн өргөдөл;

б/их сургууль, коллежид суралцагч элсүүлэх журмын дагуу элссэнийг гэрчлэх эрхийн бичгийн хуулбар;

в/энэ журмын 7-д заасан нөхцөлийг хангаж байгааг нотлон харьяалах сум, дүүргийн Засаг даргаас баталгаажуулсан албан ёсны баримт бичиг;

г/3 ба түүнээс дээш хүүхэд нь зэрэг

суралцаж байгааг нотлох сургуулийн тодорхойлолт.

9.Их сургууль, коллеж нь энэ журмын дагуу өргөдөл өгсөн суралцагчийн холбогдох материалыг бүрдүүлэн Сургалтын төрийн санд албан ёсоор хүргүүлнэ.

10.Их сургууль, коллежиос ирүүлсэн материалыг Сургалтын төрийн сан хянан үзэж, шаардагдах санхүүжилтийг сургууль тус бүрээр улирлын хуваарийн дагуу санхүүжүүлнэ.

11.Суралцагч нь улиралд 12-оос доошгүй кредит цагийн ачаалалтай, улирлын голч дүн 2-оос дээш байгаа нөхцөлд гэрээг сунгана.

12. Давтан үзэх хичээлийн сургалтын төлбөрийг суралцагч өөрөө хариуцна. Тухайн хичээлийн жилд цуглуулбал зохих кредитээс илүү гаргаж сонгосон хичээлийн сургалтын төлбөрийг суралцагч өөрөө хариуцна.

Гурав.Бусад асуудал

13. Суралцагч хуурамч материал бүрдүүлсэн нь тогтоогдвол түүнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэхээс гадна хөнгөлөлт үзүүлэхгүй.

14. Хоёр дахь дээд боловсрол эзэмшихийг хүссэн тохиолдолд энэхүү журам үйлчлэхгүй.

15. Суралцагч нь сурлага, сахилга батаар тэнцээгүй гэсэн шалтгаанаар сургуулиас хасагдсан тохиолдолд тухайн суралцагч төрөөс санхүүжүүлсэн сургалтын төлбөрийг Сургалтын төрийн санд буцааж төлнө.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487